



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/55.

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Бишрэлт ХХК-ийн “Бишрэлт” зочид буудлын 20/33, Наран саран ХХК “Рич” зочид буудлын 20/279, Их цагаан даваа ХХК-ийн “Цэнгүүн” зочид буудлын 20/392, Төгөл гоо ХХК-ийн “Бурхант” зочид буудлын 20/395, Цоглог Хангай ХХК-ийн “Титэм” зочид буудлын 20/373, Колумбас ХХК -ийн “Болор” дэн буудлын 20/257, Цоглог хараа ХХК-ийн “Элит” дэн буудлын 20/187, Омега ХХК-ийн “Номун” амралтын газрын 20/192, Аянчин Фоор Сийзонз Лодж ХХК-ийн “Аянчин Фоор Сийзонз Лодж ” амралтын газрын 20/370 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/- д үүрэг болгосугай.


7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 09
сарын 21-ний өдрийн А/55
дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 09 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Бишрэлт ХХК	5508509	Бишрэлт	ЧД-ийн, 4-р хороо, Самбуугийн гудамж
2	Наран саран ХХК	5007909	Рич	ЧД-ийн, 6-р хороо, 6-р хороолол, Их тойруу 27
3	Их цагаан даваа ХХК	2831813	Цэнгүүн	БЗД-ийн, 18-р хороо, Намьяанжүгийн гудамж 10-3 тоот
4	Төгөл гоо ХХК	5528658	Бурхант	БГД-ийн, 22-р хороо, 3-р хороолол /16090/ 61 тоот
5	Булгат мөрөн ХХК	2856352	Роял Моунтайн	ХУД-ийн, 3-р хороо, Шаравын гудамж-6
6	Цоглог Хангай ХХК	2542811	Титэм	СХД-ийн, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 105

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 09
сарын 21-ний өдрийн А/55
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

ОБТ АРДГ 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Туна ХХК	2031078	Даблю	СХД-ийн 37-р хороо, ҮЭ-41-3
2	Колумбас ХХК	2713004	Болор	БГД-ийн, 11-р хороо, Өргөө гудамж 29
3	Цоглог хараа ХХК	2542625	Элит	НД-ийн, 2-р хороо, Даваажавын гудамж Жаргалант 64
4	Тусанцаг ХХК	5066409	Тусанцаг	ЧД-ийн, 2-р хороо, 2-40 мянгатын 11-р байр 2 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 09
сарын 21-ний өдрийн А/55
дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 9 дүгээр сарын 21-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Омега ХХК	2062801	Номун	СБД-ийн, 20-р хороо, Сэлбэ зуслан
2	Баялаг орд ХХК	5292018	Баялаг ресорт	НД-ийн 6-р хороо, Горхийн баруун салаа, Өндөр улааны ард
3	Солонгот нуга ХХК	6732941	Бухын хонхор	НД-ын 6-р хороо
4	Элма баян уул ХХК	2021897	Баян-Уул	СХД-ийн, 24-р хороо, Баянхошууны баруун салаа
5	Аянчин Фоор Сийзонз Лодж ХХК	2872595	Аянчин Фоор Сийзонз Лодж	НД-ийн, 6-р хороо, Эрээний Адаг

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР